



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 11 сарын 09 өдөр

Дугаар 611

Улаанбаатар хот

┌ Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай ┐

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12<sup>1</sup> дугаар зүйлийн 12<sup>1.2</sup> дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээс даатгуулагчийн төлөөлөл болох Тээврийн цагдаагийн албаны Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Эрдэнэбатыг чөлөөлсүгэй.


2. Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд даатгуулагчийн төлөөллөөр Тээврийн цагдаагийн албаны дэд дарга бөгөөд Замын цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Ц.Ариунболдыг баталсугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 433 дугаар тогтоолын хавсралтад заасан Б.Эрдэнэбаттай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Даатгалын тухай хууль тогтоомжийг чанд мөрдөж, хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг шинээр батлагдсан гишүүн (Ц.Ариунболд)-д үүрэг болгосугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН